



НИЙТИЙН ТЭЭВРИЙН ГАЗАР,
"АВТОТЭЭВРИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ"
ТӨҮГ-Т

**МОНГОЛ УЛСЫН
ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМ**

14251 Улаанбаатар хот,
Сүхбаатар дүүрэг, Чингисийн өргөн чөлөө 11,
Утас: (976) 51-267168, Факс: (976) 11-312315,
E-mail: info@mrt.d.gov.mn, http://www.mrt.d.gov.mn

2022.05.13 № 07/2202
танай _____ -ны № _____ -т

Журам мөрдүүлэх тухай

Зам, тээврийн хөгжлийн сайдын "Журам шинэчлэн батлах тухай" 2022 оны А/112 дугаар тушаалаар "Авто үйлчилгээний байгууллагад ангилал тогтоох журам"-ыг шинэчлэн батлуулж, Захиргааны хэм хэмжээний актын нэгдсэн санд 2022 оны 05 дугаар сарын 06-ны өдөр бүртгүүлсэн.

Батлагдсан журмыг тогтоосон хугацаанд нь мөрдөх арга хэмжээ авч ажиллана уу.

Зам, тээврийн хөгжлийн сайдын "Журам шинэчлэн батлах тухай" 2022 оны А/112 дугаар тушаалаар баталсан журмын хуулбарыг хавсаргав.

Хавсралт 12 хуудастай.

АВТОТЭЭВРИЙН БОДЛОГЫН
ХЭРЭГЖИЛТИЙГ ЗОХИЦУУЛАХ ГАЗРЫН
ДАРГА *Мөрцөлсүрэн* → Е.ЖАРГАЛСАЙХАН



080002517

Захиргааны хэм хэмжээний
актын улсын нэгдсэн санд
2022 оны 05 сарын 26-ны
өдөр хүлээн авсан.



**МОНГОЛ УЛСЫН
ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН
САЙДЫН ТУШААЛ**

2022 оны 04 сарын 25 өдөр

Дугаар 0112

Улаанбаатар хот


Журам шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Автотээврийн тухай хуулийн 19² дугаар зүйлийн 19^{2.2} дахь хэсгийн заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Зам, тээврийн сайдын 2016 оны "Журам батлах тухай" 90 дүгээр тушаалын нэгдүгээр хавсралтаар баталсан "Авто үйлчилгээний байгууллагад ангилал тогтоох журам"-ыг хавсралтаар шинэчлэн баталсугай.

2. Энэ журмыг 2022 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

3. Энэхүү тушаал хүчин төгөлдөр болсон өдрөөс Зам, тээврийн сайдын 2016 оны "Журам батлах тухай" 90 дүгээр тушаалын нэгдүгээр хавсралтаар баталсан "Авто үйлчилгээний байгууллагад ангилал тогтоох журам"-ыг хүчингүй болсонд тооцсугай.



Л.ХАЛТАР

Бүрэлдлийн дугаар 197
МОНГОЛ УЛСЫН
ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМ
ХУУЛЬСАР ҮНЭН
2022 оны 7 сарын 25 өдөр

Зам, тээврийн хөгжлийн сайдын 2022 оны
04 дугаар сарын 15-ны өдрийн 15/Дугаар



АВТО ҮЙЛЧИЛГЭЭНИЙ БАЙГУУЛЛАГАД АНГИЛАЛ ТОГТООХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү журмын зорилго нь Монгол Улсын нутаг дэвсгэрт авто тээврийн хэрэгслийн ашиглалттай холбогдон гарах үйлчилгээ эрхэлж байгаа иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд (цаашид "авто үйлчилгээ эрхлэгч" гэх) эрх бүхий байгууллагаас ангилал тогтооходой холбоотой харилцааг зохицуулахад оршино.

1.2. Энэхүү журмыг өмчийн төрөл харгалзахгүй авто үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж буй иргэн, аж ахуйн нэгж, байгууллага болон ангилал тогтоох, хяналт тавих эрх бүхий байгууллага, албан тушаалтан дагаж мөрдөнө.

1.3. Холбогдох хууль тогтоомжийн дагуу эрх бүхий байгууллагаар ангилал тогтоолгоогүй иргэн, аж ахуйн нэгж байгууллагын үйл ажиллагааг мэдээллийн санд бүртгэж, олон нийтэд мэдээлэхгүй.

1.4. Авто үйлчилгээний байгууллагад ангилал тогтоох үйл ажиллагааг автотээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас эрх олгогдсон байгууллага гүйцэтгэнэ.


1.5. Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.2 дэх заалтыг үндэслэнэ.

1.6. Энэ журамд ашигласан нэр томъёог Автотээврийн тухай хууль, Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хууль, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль, "Авто үйлчилгээ", "Авто үйлчилгээ эрхлэгч" гэж "Авто үйлчилгээнд тавих Ерөнхий шаардлага" MNS5025:2020 стандарт болон бусад хууль тогтоомжид дурдсан улгаар ойлгоно.

Хоёр. Ангилал тогтоох үйл ажиллагааны зохион байгуулалт

2.1. Авто үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх иргэн, аж ахуйн нэгж, байгууллага нь ангилал тогтоох эрх бүхий байгууллагаар үйлчилгээний ангиллаа тогтоолгосны үндсэн дээр үйлчилгээ эрхэлнэ.

2.2. Ангилал тогтоох эрх бүхий байгууллага нь ангилал тогтоолгох хүсэлтийг хүлээн авах, бүртгэх, хянан үзэж шийдвэрлэх, мэдээллийн сан бүрдүүлэх, гэрээ байгуулах, ангилал тогтоолгосон гэрчилгээ олгох зэрэг ажлыг зохион байгуулна.



2.3. Үйлчилгээний ангиллыг тогтоохдоо тохирлын баталгаа, улсын байцаагчийн эсвэл шинжээчийн дүгнэлтэд үндэслэн тогтооно.

2.4. Ангилал тогтоохдоо дараах зарчмыг баримтална:

2.4.1. Бие даасан, хараат бус байх;

2.4.2. Ил тод, шуурхай, шударга байх;

2.4.3. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага үйлчилгээ эрхлэхэд таатай орчныг бүрдүүлэх, адил тэгш нөхцөл олгох;

2.5. Ангилал тогтоох үйл ажиллагаа нь цахим хэлбэрээр явагдах бөгөөд шаардлагатай тохиолдолд газар дээр нь үзэх, тодруулга хийж болно.

2.6. Авто үйлчилгээ эрхлэгч нь ангилал тогтоолгох хүсэлтээ мэдээллийн сан дах маягтын дагуу ангилал тогтоох эрх бүхий байгууллагад цахимаар гаргана.

2.7. Ангилал тогтоолгох хүсэлтэд дараах материалыг хавсаргана. Үүнд:

2.7.1. Аж ахуйн нэгжийн гэрчилгээний хуулбар (иргэний нэр дээр үйл ажиллагаа явуулах бол иргэний үнэмлэхний хуулбар);

2.7.2. Үйлчилгээний хүчин чадал, тоног төхөөрөмжийн тухай товч танилцуулга;

2.7.3. Тохирлын гэрчилгээний хуулбар;

2.7.4. Улсын байцаагчийн эсвэл шинжээчийн дүгнэлт;

2.7.5. Үйлчилгээний нэр төрөл, тэдгээрийг гүйцэтгэх технологийн харт;

2.7.6. Үйлчилгээний үнэ тариф, ажиллах цагийн хуваарь;

2.7.7. Үл хөдлөх хөрөнгийн гэрчилгээний хуулбар эсвэл түрээсийн гэрээний хуулбар;

2.7.8. Галын аюулгүй байдлын дүгнэлт

2.7.9. Авто угаалгын үйлчилгээ эрхлэгч мэргэжлийн байгууллагын дүгнэлт гаргуулах.

2.8. Ангилал тогтоох эрх бүхий байгууллага нь хүсэлтийг хүлээн авснаар хянан үзэж ажлын 15 хоногийн дотор "Авто үйлчилгээнд тавих Ерөнхий шаардлага" MNS5025:2020 стандартад заасан төрлийн үйлчилгээ эрхлэх ангиллын гэрчилгээ олгох асуудлыг шийдвэрлэнэ.

2.9. Ангилал тогтоох эрх бүхий байгууллагын эрх, үүрэг


2.9.1. Ангилал тогтоолгох хүсэлтийг хүлээн авч хянан үзэж шаардлага хангаж буй тохиолдолд зохих ангиллын гэрчилгээг тогтоосон хугацаанд олгох;

2.9.2. Тухайн ангиллын үйлчилгээ эрхлэхэд тавигдах нөхцөл шаардлага хангаагүй тохиолдолд ангилал тогтоож, гэрчилгээ олгохоос татгалзах;

2.9.3. Ангилал тогтоолгосон үйлчилгээ эрхлэгчийн дэлгэрэнгүй мэдээллийг мэдээллийн санд бүртгэх;

2.9.4. Ангилал тогтоолгосон байгууллагад мэдээллийн санд техникийн үйлчилгээ, засварын тухай мэдээлэл оруулах эрх олгох, эрхийг цуцлах;

2.9.5. Ангилал тогтоолгосон байгууллагатай гэрээ байгуулах, гэрээг тогтоосон хугацаанд дүгнэх, ангиллын гэрчилгээг сунгах, хүчингүй болгох;



2.9.6. Ангилал тогтоолгосон байгууллагын үйл ажиллагааг олон нийтэд сурталчлах, мэргэжил арга зүйн зөвлөмжөөр хангах;

2.9.7. Гэрээний нөхцөл, шаардлагыг биелүүлж байгаад хяналт, шалгалт тавих;

2.9.8. Авто үйлчилгээний мэдээллийн сангийн аюулгүй байдал, найдвартай ажиллагаа, шинэчлэлийг хариуцна;

2.9.9. Авто үйлчилгээний талаарх статистик мэдээ тайланг жилийн эхний хагас болон жилийн эцэс, мөн шаардлагатай тохиолдолд тухай бүр нь гарган автотээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

2.10. Ангилал тогтоох эрх бүхий байгууллага нь ангилал тогтоолгосон байгууллагатай тухайн ажил үйлчилгээг төрөл, хүчин чадал, технологийн карт, цагийн хуваарийн дагуу үзүүлэх талаар болон тухайн хоёр байгууллагын эрх, үүрэг, хариуцлагын тухай тохиролцож гэрээ байгуулна.

2.11. Ангилал тогтоолгох хугацаа, түүнийг сунгах

2.11.1. Ангилал тогтоосон гэрчилгээг холбогдох жууль тогтоомжийн дагуу тогтоосон хугацаагаар олгоно.

2.11.2. Тухайн үйлчилгээний ангиллын хугацааг сунгахдаа улсын байцаагчийн эсвэл шинжээчийн дүгнэлтийг үндэслэн анх олгосон хугацаанаас доошгүй хугацаагаар сунгаж болно.

2.11.3. Тухайн үйлчилгээний байгууллагад тавигдах нөхцөл шаардлагыг зөрчсөн тохиолдолд гэрчилгээний хугацааг сунгахгүй.

2.12. Тогтоосон ангиллыг түр түдгэлзүүлэх.

2.12.1. Үйл ажиллагаанд тавигдах нөхцөл шаардлагыг зөрчсөн тохиолдолд мэргэжлийн хяналтын байгууллага, автотээврийн хяналтын улсын байцаагчийн дүгнэлтийг үндэслэн ангилал тогтоосон эрх бүхий байгууллага түүнийг 3 сар хүртэл хугацаагаар түдгэлзүүлж болно.

2.12.2. Үйл ажиллагааг түдгэлзүүлсэн нөхцөл тарилсан тухай мэргэжлийн хяналтын байгууллага, автотээврийн хяналтын улсын байцаагчийн дүгнэлтийг үндэслэн ангилал тогтоосон эрх бүхий байгууллага тогтоосон ангиллыг сэргээнэ. Тогтоосон ангиллыг сэргээхдээ анх олгосон хугацаанаас нь үргэлжлүүлнэ.

2.13. Ангилал тогтоосон эрх бүхий байгууллага нь дараах тохиолдолд ангилал тогтоосныг хүчингүйд тооцно. Үүнд:

2.13.1. Эзэмшигч хүсэлт гаргасан;

2.13.2. Хуулийн этгээд татан буугдсан;


2.13.3. Гэрчилгээнд заасан төрлийн үйлчилгээг шалтгаангүйгээр гурван сараас дээш хугацаагаар эрхлээгүй буюу тавигдах шаардлагыг хангахгүй болсон;

2.13.4. Үйлчлүүлэгчдээс удаа дараа (2 ба түүнээс дээш) гомдол гарч тэр нь мэргэжлийн байгууллагаас үндэслэлтэй гэж тогтоосон;

2.13.5. Ангиллын гэрчилгээг бусдад шилжүүлсэн, худалдсан, барьцаалсан;

2.13.6. Гэрээгээр хүлээсэн үүргээ ноцтой зөрчсөн;

2.13.7. Авто үйлчилгээ эрхлэгч нь "Авто үйлчилгээний мэдээллийн сан"-д техникийн үйлчилгээ, засварын тухай мэдээллээ тогтмол оруулаагүй.



2.14. Эрх бүхий байгууллага, албан тушаалтны шийдвэрээр авто үйлчилгээний байгууллагын үйл ажиллагааг түдгэлзүүлсэн, хүчингүйд тооцсон тохиолдолд ангилал тогтоосон эрх бүхий байгууллага энэ тухай олон нийтэд мэдээлнэ.

2.15. Авто үйлчилгээ эрхлэгч нь тогтоолгосон ангиллаа өөрчлөх, нэмэгдүүлэх тохиолдолд зөвхөн тухай ангилалд хамаарах хүрээнд улсын байцаагчийн эсвэл шинжээчийн дүгнэлт гаргуулна.

2.16. Тохирлын баталгаа, улсын байцаагчийн эсвэл шинжээчийн дүгнэлтэд үндэслэн үйлчилгээний ангиллыг дахин тогтоон гэрчилгээ олгоно.

2.17. Үйлчилгээ эрхлэгч нь олон байршилд үйл ажиллагаа эрхлэх бол салбар тус бүрт ангилал тогтоолгон гэрчилгээ авсан байна.

2.18. Авто үйлчилгээ эрхлэгч нь "Авто үйлчилгээний мэдээллийн сан"-д техник үйлчилгээ, засварын тухай мэдээллээ тогтмол оруулна.

2.19. Үйлчлүүлэгч нь үйлчилгээтэй холбоотой гомдлоо тухайн байгууллагын удирдлагад гаргаж шийдвэрлүүлнэ. Хэрэв тухайн үйлчилгээний байгууллага гомдлыг шийдвэрлээгүй, гаргасан шийдвэр үйлчлүүлэгчийн шаардлагыг хангаагүй тохиолдолд эрх бүхий эсвэл хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах байгууллагад хандаж шийдвэрлүүлнэ. Үйлчилгээтэй холбоотой гомдлыг холбогдох байгууллага 14 хоногийн дотор шалгаж хариу өгнө.

2.20. Авто үйлчилгээ эрхлэгч тухайн ангиллын авто үйлчилгээг эрхлэх гэрчилгээ, мэргэжлийн байгууллагатай байгуулсан гэрээг цахимаар авч ашиглана.

Гурав. Авто үйлчилгээ эрхлэгчийн нийтлэг эрх, үүрэг.

3.1. Авто үйлчилгээ эрхлэгч нь дараах эрх эдэлнэ.

3.1.1. мэргэжлийн байгууллагаар ажил үйлчилгээнийхээ чанар, байдлыг үнэлүүлж зохих ангилал тогтоолгох;


3.1.2. Үйлчилгээтэй холбоотой холбогдох мэдээллээ нэгдсэн санд бүртгүүлэх;

3.1.3. Шаардлагатай асуудлаар саналаа эрх бүхий байгууллагад тавьж шийдвэрлүүлэх.

3.2. Авто үйлчилгээ эрхлэгчийн үүрэг.

3.2.1. Ажил, үйлчилгээний талаарх мэдээллээ нэгдсэн мэдээллийн санд байршуулах;

3.2.2. Тээврийн хэрэгсэлд техникийн үйлчилгээ, засвар хийхдээ үйлдвэрлэгчээс тогтоосон техникийн норм, дүрэм, зааварчилгааг мөрдлөг болгон



ашиглах бөгөөд технологийн карт, аюулгүйн ажиллагааны дүрэм боловсруулж мөрдөн ажиллах;

3.2.3. Техникийн үйлчилгээ, засварын үнэ тарифыг тогтоох, үйлчилгээндээ үндэслэлтэй тогтоосон үнэ тарифыг мөрдөх;

3.2.4. Үйлчилгээндээ баталгаат хугацаа тогтоох, баталгаат хугацаанд техникийн үйлчилгээ, засварыг хэрэглэгчид үзүүлэх;

3.2.5. Тээврийн хэрэгсэлд хийсэн засвар, үйлчилгээний мэдээллийг тухай бүрт нь мэдээллийн санд бүртгэж оруулах;

3.2.6. Авто үйлчилгээ эрхлэгч нь "Хог хаягдлын тухай" хуулийн 10.2.4-д "Хог хаягдлаа зориулалтын хогийн сав болон цэгт хаях эсвэл хог хаягдал цуглуулж тээвэрлэх эрх бүхий байгууллагад шилжүүлэх" гэж заасны дагуу хамтран ажиллах;

3.2.7. Авто угаалгын үйлчилгээ эрхлэгч иргэн, аж ахуйн нэгж, байгууллага усаа дахин цэвэршүүлэх төхөөрөмжийг ашиглах;

3.2.8. Энэ журмын 2.6-д заасны дагуу хүсэлтээ илгээхдээ барилга байгууламж, тоног төхөөрөмжийн тод харагдахуйц зураг, хүний нөөц, үйлчилгээний газрын байршил, нэр, хаягийн мэдээллийг хавсаргана.


3.2.9. Холбогдох хууль тогтоомжийн хүрээнд орон нутгийн засаг захиргаатай гэрээ байгуулж ажиллана.

Дөрөв. Хяналт тавих эрх бүхий байгууллагын эрх, үүрэг

4.1. Авто үйлчилгээ эрхлэгчдийн үйл ажиллагаанд тавих захиргааны хяналтыг автотээврийн хяналт, шалгалтын асуудал эрхэлсэн төв байгууллага болон нутгийн захиргааны байгууллагын мэргэжлийн хяналтын алба, автотээврийн хяналтын улсын байцаагч хэрэгжүүлнэ.

4.2. Ажил үйлчилгээний талаарх мэдээллээ нэгдсэн мэдээллийн санд тогтмол байршуулдаг авто үйлчилгээ эрхлэгчдийн үйл ажиллагааг эрх бүхий байгууллага олон нийтэд мэдээлэх үүрэгтэй.

—oOo—



Ангилал тогтоох эрх бүхий
байгууллагын таних тэмдэг

Хавсралт А

АВТО ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АНГИЛЛЫН ГЭРЧИЛГЭЭ

ХХК-д

...-ын захирал (дарга)-ын 20... оны ... дугаар сарын ...
(ангилал тогтоосон байгууллагын нэр)
едрийн ... тоот тушаалыг үндэслэн авто үйлчилгээний ангиллын гэрчилгээ олгов.

ГАРЫН ҮСЭГ

Гэрчилгээ олгосон огноо

Хүчинтэй хугацаа

Энэхүү гэрчилгээ нь гэрээний хамт хүчинтэй.

/Гэрчилгээний арын нүүр/

Аж ахуйн нэгж байгууллага, иргэний нэр:
(ангилал тогтоолгосон байгууллага)

1. Регистер:

2. Үйлчилгээний газрын хаяг:

... аймаг (нийслэл)-ийн ... сум (дүүрэг)-ын ...
хорооны нутаг дэвсгэрт байрлах

2. Авто үйлчилгээний ангилал:


д/д	Төрөл	Хүчинтэй хугацаа
1.		
2.		
3.		

3. Нэмэлт өөрчлөлт:

д/д	Нэмэлт өөрчлөлтийн агуулга	Бүртгэсэн	
		Огноо	Ажилтан, тэмдэглэл

Энэхүү гэрчилгээ нь засвартай бол хүчингүй.

—ооо—



**АВТО ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АНГИЛАЛ ТОГТООЛГОХ
БАЙГУУЛЛАГААС АВАХ ЦАХИМ ХҮСЭЛТИЙН ЗАГВАР**

Хавсралт Б


Нэг. Аж ахуйн нэгж, байгууллага, иргэний мэдээлэл

№	Байгууллагын мэдээлэл	Танилцуулга
1	Аж ахуйн нэгж, байгууллага, иргэний нэр	
2	Байгууллагын хаяг	
3	Үйлчилгээний газрын нэр	
4	Үйл ажиллагааны чиглэл	
5	Үйлчилгээний газрын хаяг	
6	Улсын бүртгэлийн гэрчилгээний №	
7	Байгууллагын регистр	
8	Өмчийн хэлбэр	
9	Тухайн чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж буй хугацаа	
10	Удирдлагын нэр, холбогдох утас, майл хаяг	

Хоёр. Ангилал тогтоолгох хүсэлт

№	Ажил үйлчилгээний төрөл	Ангилал	Хүсэлт
Техникийн оношилгоо, үйлчилгээ, засвар			
Тээврийн хэрэгслийн ашиглалтын хугацаанд техникийн бүрэн бүтэн байдал, найдвартай ажиллагааг хангахад чиглэгдсэн бүх төрлийн техникийн оношлогоо, үйлчилгээ, засвар зэрэг хамаарна.			
1	Агрегат зангилаа, механизм, оношлогоо, засвар		
2	Техникийн үйлчилгээ		
3	Хөдөлгүүрийн оношилгоо, техникийн үйлчилгээ, засвар, тохиргоо, зүгшрүүлэлт		
4	Түлшний систем засвар, тохиргоо, зүгшрүүлэлт		
5	Ажилласан хий (утаа)-г зайлуулах систем, яндангийн дуу, чимээ намсгагч, ажилласан хийг гаргах систем (EGR), DPF, DOC, катализаторын хувиргагч гэх мэт оношилгоо, засвар, техникийн үйлчилгээ, тохиргоо, зүгшрүүлэлт		
6	Радиатор, хөргөлт, агааржуулалтын системийн оношилгоо, техникийн үйлчилгээ, засвар, тохиргоо, зүгшрүүлэлт		
7	Хурдны хайрцаг, хүч дамжуулах ангийн оношилгоо, техникийн үйлчилгээ, засвар		
8	Жолооны механизм, явах ангийн оношилгоо, техникийн үйлчилгээ, засвар, тохиргоо, зүгшрүүлэлт		

197


 ХУУЛЬСАР АЖИРААГАА
 Хуульсар бэлтгэх ажлын гэрэл үсэг
 2019 оны 09 сарын 15-ний өдөр


9	Их биеийн засвар		
10	Угаалга, цэвэрлэгээ үйлчилгээ		
11	Цахилгаан систем, түүний тоноглол, хэрэгсэл болон цахилгаан хөдөлгүүрийн системийн оношилгоо, техникийн үйлчилгээ; засвар, тохиргоо, зүгшрүүлэлт		
12	Резин дугуй засвар, дугуйн баланс тохируулга, зүгшрүүлэлт		
13	Автомашин шил засварлах, суурилуулах үйлчилгээ		
Автотээврийн хэрэгсэл түүний сэлбэг, хэрэгсэл, эд ангийн худалдаа; автотээврийн хэрэгсэл түүний сэлбэг хэрэгсэл, эд анги, цахилгаан тоноглол, гуслах тоног, төхөөрөмж, ашиглалтын бусад материалын бөөний болон жижиглэнгээр худалдаалах зэрэг үйлчилгээ үзүүлэх газар			
1	Автотээврийн хэрэгсэл		
2	Автотээврийн хэрэгслийн сэлбэг, хэрэгсэл		
3	Тос, тосолгооны болон ашиглалтын бусад материал		
4	Оёдол доторлогоо үйлчилгээ		
5	Тээврийн хэрэгслийн резин дугуй, обуд		
Автотээврийн хэрэгсэл, түүний эд анги хадгалах үйлчилгээ; автотээврийн хэрэгслийг урт, богино хугацаагаар хадгалах авто зогсоол, түүнтэй нийцсэн бусад үйлчилгээг төлбөртэйгээр үзүүлэх			
1	Авто зогсоол		
2	Тээврийн хэрэгслийн агрегат зангилаа, эд анги, сэлбэг, хэрэгсэл хадгалах		

Гурав. Үйлдвэрлэл үйлчилгээний барилга байгууламж

№	Барилга байгууламж	Нэгж	Тайлбар
1	Байршил, Хаяг		
2	Байрны эзэмшил		өөрийн түрээсийн
3	Үйлдвэрлэлийн байрны хэмжээ	м ²	
4	Зогсоолын талбай	м ²	
5	Галын аюулгүй байдлыг хангасан байдал	ОБГ-ын дүгнэлт	
6	Байгаль орчны нөлөөллийн үнэлгээ хийлгэсэн дүгнэлт	БО-ын дүгнэлт	
7	Ажилчдын хувцас солих өрөө	м ²	
8	Амрах өрөө	м ²	
9	Бие засах газар, гар угаах газар	Тоо	

Дөрөв. Технологийн тоног төхөөрөмж

№	Нэрс	Танилцуулга



1	Технологийн карт	
2	Тоног төхөөрөмжийн товч танилцуулга	
3	Тоног төхөөрөмжийн тоо хэмжээ	
4	Тоног төхөөрөмжийн хүчин чадал	
5	Тоног төхөөрөмжийн баталгаажилт	
6	Тоног төхөөрөмжийн насжилт	
7	Аюулгүй ажиллагааны зааварчилгаа	

Тав. Хүний нөөц

№	Ажлын байрны нэр	Инженер техникийн ажилтны тоо	Мэргэшсэн байдал


**АВТО ҮЙЛЧИЛГЭЭ ЭРХЛЭГЧ ИРГЭН АЖ АХУЙН НЭГЖ,
БАЙГУУЛЛАГА БҮРТГЭХ МЭДЭЭЛЭЛ**

Нэг. Байгууллагын мэдээлэл

1	Аж ахуйн нэгж, байгууллага, иргэний нэр	
2	Байгууллагын хаяг	
3	Үйл ажиллагааны чиглэл	
4	Улсын бүртгэлийн гэрчилгээний №	
5	Байгууллагын регистр	
6	Өмчийн хэлбэр	
7	Удирдлагын нэр холбогдох утас, мэйл хаяг	
8	Авто үйлчилгээний ангилал, төрөл	
9	Тухайн чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж буй хугацаа	
10	Ангилал тогтоолгосон хугацаа	
11	Дуусах хугацаа	

Хоёр. Хүний нөөцийн мэдээлэл

1	Овог	
2	Нэр	
3	Албан тушаал	
4	Регистрийн дугаар	
5	Хүйс	
6	Иргэншил	
7	Мэргэжил	
8	Мэргэшил	




9	Мэргэжлийн үнэмлэх, дипломын дугаар	
10	Мэргэжлээрээ ажилласан жил	
11	Тухайн байгууллагад ажилласан жил	

Гурав. Барилга байгууламж

1	Байршил, Хаяг		
2	Байрны эзэмшил		
3	Үйлдвэрлэлийн байрны хэмжээ	м ²	
4	Зогсоолын талбай	м ²	
5	Галын аюулгүй байдлыг хангасан байдал	ОБГ-ын дүгнэлт	
6	Ажилчдын хувцас солих өрөө	м ²	
7	Амрах өрөө	м ²	
8	Бусад		

-----000-----



Хавсралт В

ЭРХ БҮХИЙ БАЙГУУЛЛАГЫН ОРУУЛАХ МЭДЭЭЛЭЛ

Нэг. Тээврийн цагдаагийн байгууллага
Зам, тээврийн осолд холбогдсон гэмтэл

- Их гэмтэлтэй
- Дунд гэмтэлтэй
- Бага гэмтэлтэй

Хоёр. Онцгой байдлын байгууллага

	Их гэмтэлтэй	Дунд гэмтэлтэй	Бага гэмтэлтэй
Гал түймэрт өртсөн			
Үер, усанд өртсөн			
Бусад			

Гурав. Даатгалын байгууллага

- Даатгагч байгууллагын нэр
- Даатгалын хүчинтэй хугацаа
- Нөхөн олговрын мэдээлэл

Дөрөв. Тээврийн хэрэгслийн техникийн хяналтын байгууллага

- Техникийн хяналтын үзлэгийн мэдээлэл

Тав. Тээврийн хэрэгслийн бүртгэлийн байгууллага

- Өмнөх эзэмшигчийн мэдээлэл
- Тухайн тээврийн хэрэгслийн хязгаарлалт

Зургаа. Гаалийн байгууллага

- Эвдрэл гэмтлийн мэдээлэл
- Нийт явсан гүйлт

Долоо. Татварын ерөнхий газар

- Татварын түүх

Найм. Үнэлгээний байгууллага

- Эвдрэл гэмтлийн мэдээлэл

— 000 —

